

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗАР**



Ажлаасуудын туршид үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын судалгаа

ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН СУДАЛГАА



2015



Агуулга

Оршил

Нэг. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Хоёр. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт

Гурав. Барилгын салбар

Дөрөв. Зам, тээвэр

Тав. Холбоо

Хүснэгтийн жагсаалт

1. Бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо, салбараар
2. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр
3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, оны үнээр, тэрбум төг
4. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, салбар, дэд салбар, сая төгрөг
5. Аж үйлдвэрийн мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо
6. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр
7. Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо
8. Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж, салбар, дэд салбар, мян төг
9. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр, сая төг
10. Барилга угсралт, их засварын ажил, сая төгрөг, сумаар
11. Ашиглалтанд оруулсан орон сууц, м2, оны эцэс
12. Авто тээврийн үзүүлэлт, оны эцэст
13. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, оношлогоонд хамрагдсан тээврийн хэрэгсэлийн тоо, сумдаар, оны эцэст
14. Холбоо шуудан, оны эцэст
15. Телефон утасны сүлжээний байршил, 2014 оны 12-р сарын 31-ний байдлаар
16. Үүрэн телефоны үзүүлэлт, оны эцэст

Зургийн жагсаалт

1. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сая төгрөг
2. Бүтээгдэхүүний борлуулалт, сая төгрөг
3. Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо, аймгийн нийт ажиллагчдын тоонд эзлэх хувь
4. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, мян төг
5. Ашиглалтанд оруулсан орон сууцанд амьдарч буй өрх, хүн амын тоо

Дүгнэлт

ОРШИЛ

Газар зүйн байрлалын хувьд эх орны өмнөд хязгаарт 109,4 мян.км² нутгийг эзлэн, урд талаараа БНХАУ-тай баруун, хойд, зүүн талаараа Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хиллэн оршино. Аймгийн нутаг бүхэлдээ говийн бүсэд багтдаг боловч нутгийн өмнөд хэсэг нь говь, хойд хэсэг нь говь хээр хосолсон нутаг юм. Аймгийн нутаг эх газрын хувьд эрс тэс уур амьсгалтай.

Төмөр зам тус аймгийн нутгаар 500 гаруй км үргэлжилсэн ачаа, зорчигч тээн аймгийн төвийг улсын нийслэлтэй болон өмнөд хөрштэй холбодог юм. Энэ замын дагуу Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд зэрэг төмөр замын өртөө суурин бий. Бусад сумдад хүн, шуудан, ачаа тээврийг авто машинаар гүйцэтгэж байна.

Тус аймагт 1940 оны дунд үеэс анхны үйлдвэрүүдийн суурь тавигдсан бөгөөд гар үйлдвэрийн артель, хүнсний үйлдвэр, хэвлэх үйлдвэр эхлэн байгуулагдсан юм. 1960-1980 онуудад мод боловсруулах үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр, нэгдэл дундын үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, уулын баяжуулах үйлдвэрүүд байгуулагдсан бөгөөд 1980-аад оны дунд үеэс карьер боловсруулах үйлдвэр, хүнсний бусад үйлдвэрүүд байгуулагдсан билээ. Зах зээлийн эдийн засагт шилжсэн 1994 оны дунд үеэс тус аймагт жижиг үйлдвэр эрхлэх идэвхи санаачлага эрс нэмэгдсэн билээ. 1991, 1992 онд улсын үйлдвэр байсан мод, ахуйн үйлчилгээний чиглэлийн үйлдвэрүүд хувьчлагдан, хэд хэдэн жижиг үйлдвэр байгуулагдсан юм. Тухайлбал: 1992 онд ахуйн үйлчилгээний чиглэлийн жижиг үйлдвэр Айраг суманд 2, Даланжаргалан суманд 1, Дэлгэрэх суманд 2, Иххэт суманд 1, Мандах суманд 1, Хатанбулаг суманд 1, Хөвсгөл суманд 1, Сайншанд суманд 3 тус тус ажиллаж байжээ.

Аж үйлдвэрийн салбар нь эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын дагуу уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, хий, дулаан, уур усан хангамж гэсэн гурван салбараас бүрдэж байна. Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтэд аж ахуйн нэгж байгууллагуудын ажиллагчид, зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэр газруудын сар улирал, жилийн тайлан юм.

НЭГ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО

Манай аймгийн хэмжээнд 2014 оны байдлаар 1088 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 841 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна .

1. БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, салбараар

Салбарын ангилал	2010	2011	2012	2013	2014
БҮГД	697	847	905	983	1088
Хөдөө аж ахуй, ан агнуур	13	24	36	35	39
Уул уурхай олборлох үйлдвэр	8	12	14	12	16
Боловсруулах үйлдвэр	35	49	48	55	54
Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	5	4	2	2	10
Барилга	14	18	23	31	40
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	266	209	245	276	280
Зочид буудал, зоогийн газар	52	66	79	86	84
Тээвэр агуулахын аж ахуй, Холбоо	19	39	37	49	75
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	21	113	74	85	85
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	20	50	53	54	58
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	66	52	53	52	54
Боловсролын салбарын үйл ажиллагаа	54	61	63	63	65
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	50	55	61	61	56
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйл ажиллагаа	74	95	117	122	172

2014 онд үйл ажиллагаа явуулж байгаа 841 аж ахуйн нэгжээс аж үйлдвэрийн салбар буюу уул уурхайн олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэр, цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 48 ААН үйл ажиллагаа явуулж байна.

2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр

Салбарын ангилал	2012	2013	2014	Ажиллагчдын тооны бүлэг			
				1-9	10-19.	20-49	50+
БҮГД	607	648	841	674	82	59	26
Хөдөө аж ахуй	16	17	29	26	3		
Уул уурхай, олборлох үйлдвэр	7	2	7	6	1		
Боловсруулах үйлдвэр	20	22	37	34	2	1	
Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	1	1	4	2			2
Барилга	15	16	30	20	4	5	1
Бөөний болон жижиглэн	147	162	220	213	4	2	1
Зочид буудал, зоогийн газар	61	63	63	50	11	2	
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	19	32	55	49	3	1	2
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	52	59	65	64		1	
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	39	43	51	47	2	1	1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл	63	50	50	19	17	9	5
Боловсролын салбарын үйл ажиллагаа	49	50	53	12	16	15	10
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл	56	56	52	24	19	8	1
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	62	75	125	108		14	3

ХОЁР. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагуудын ажиллагчдын тоо, зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, нэр төрлөөр, биет хэмжээ, үнийн дүнгээр. бүтээгдэхүүний борлуулалтын үзүүлэлтүүдийг оруулдаг. Аж үйлдвэрийн салбарын ангилал, аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн ангилалаар ангилахдаа салбарын стандартыг мөрдөж байна.

Үндсэн ойлголт, тодорхойлолт:

Бүтээгдэхүүн гэж бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлтэд завсрын хэрэглээний орц хэлбэрээр, эсвэл хүн амын эцсийн хэрэглээ болж ашиглагдах зорилгоор үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон биет зйлийг хэлнэ.

Нийт үйлдвэрлэлт гэж аж ахуй нэгж байгууллага, иргэдийн өөр нэгж байгууллагын хэрэгцээнл болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт хэмжээг хэлнэ.

Аж үйлдвэрийн салбарт оны үнээр 11,1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 12,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд борлууллаа.

Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өмнөх оноос 12,3 хувиар нэмэгдэж, борлуулалт 3,2 хувиар буурсан байна. Хайрга олборлолт, гөлтгөнө олборлолт, бетон зуурмагын үйлдвэрлэлт шинээр нэмэгдсэн нь нийт бүтээгдэхүүн өсөхөд нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4,1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 7,8 хувиар нэмэгдлээ.

3. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014
Улсындүн	4468,2	5626,7	6058,0	6456.6	11076.5
Төвийн бүс	714.9	1033.8	1019.3	930.4	1188.3
Дорноговь аймаг	13.0	4.3	18.3	13.2	12.7
Улсын дүнд эзлэх хувь	0.1	0.1	0.3	0.2	0.1
Бүсийн дүнд эзлэх хувь	0.5	0.4	1.8	1.4	1.1

4. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбар, дэд салбар, сая төгрөг

Салбар	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$
Дүн	11666.1	9852.6	11067.4	112.3
Уул уурхай олборлох аж үйлдвэр	8039.4	5122.9	3809.7	74.4
Нүүрс олборлолт	8039.4	5122.9	2690.8	52.5
Бусад ашигт малтмал олборлолт			1118.9	
Боловсруулах аж үйлдвэр	748.4	705.1	1356.8	192.4
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	338.5	394.1	487.1	123.6
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	46.1	53.6	45.4	84.7
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	44.4	49.9	51.8	103.8
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	248.1	290.6	389.9	134.2
Хувцас үйлдвэрлэл	26.5	35.1	59.5	169.5
Гутал үйлдвэрлэл	0.5	3.9	19.5	499.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	14.6	38.9	19.0	48.8
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр				
эдлэл үйлдвэрлэл	1.1	9.4	1.7	18.4
Боловсруулах үйлдвэрийн бусад	367.3	223.8	770.0	344.1
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2878.3	4024.6	5900.9	146.6
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	2221.8	3229.8	4638.0	143.6
Ус ариутгал, усан хангамж	656.5	794.8	1262.9	158.9

5. АЖ ҮЙЛДВЭРИЙН МЭДЭЭНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ТОО


Салбар	ААН	ИРГЭН
Дүн	24	111
Уул уурхай олборлох аж үйлдвэр	4	
Нүүрс олборлолт		
Бусад ашигт малтмал олборлолт	4	
Боловсруулах аж үйлдвэр	19	109
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11	44
Хувцас үйлдвэрлэл		24
Гутал үйлдвэрлэл		8
Мод, модон эдлэл үйлдвэрлэл		9
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр		
эдлэл үйлдвэрлэл	1	3
Боловсруулах үйлдвэрийн бусад	7	21
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	1	2
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	1	2
Ус ариутгал, усан хангамж		

Сар бүрийн аж үйлдвэрийн салбарын мэдээнд нийт 135 нэгж хамрагдсанаас 111 нь өрхийн аж ахуй эрхэлсэн иргэд байна.


Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь ангилж үзвэл цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 53,4 хувь, уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 34,4 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 7,8 хувь, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4,4 хувийг тус тус эзэлж байна.

2014 онд оёдол -1, вакуум цонхны үйлдвэрлэл-2, барилгын материал үйлдвэрлэл 2, хоршоо 1, уул уурхайн 3, усан хангамжийн салбарын 1 аж ахуйн нэгж, иргэд шинээр үйлдвэрлэл байгуулагджээ.

ЗУРАГ 1. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, оны үнээр, сая төгрөг



ЗУРАГ 2. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, сая төгрөг



2013 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтйн 52,6 хувийг компани, 42,4 хувийг улсын үйлдвэрийн газар, 5,0 хувийг өрхийн аж ахуй, хоршоо, тус тус үйлдвэрлэжээ.

6. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр

	Хэмжих нэгж	Онууд						2014 2013	
		2009	2010	2011	2012	2013	2014		
1	Цахилгаан	мян.квт.ц	92.5	152.7	241.5	244.7	401.1	443.8	110.6
2	Дулаан	мян.ккал	43.1	54.1	51.8	60.3	68.5	68.9	100.6
3	Төмрийн хүдэр	мян.тн						4.6	
4	Хайрга	мян.м3						37.1	
5	Талх	тн	144.1	59.7	42.2	54.8	91.1	83.0	91.1
6	Нарийн боов	тн	24.6	23.6	46.7	55.1	45.4	51.0	112.3
7	Бялуу	тн	0.02	0.03	1.70	1.3	3.4	1.75	51.5
8	Архи	мян.л	5.7	7.1	4.8	3.6	2.8		
9	Хиам	тн	16.8	8.4	11.7	9.9	9.0	7.8	86.7
10	Зайрмаг	мян.шир	16.7	20.2	33.1	42.9	22.7	5.8	25.6
11	Модон эдлэл	мян.төг	6537.0	8682.5	18043.4	14719.0	38970.0	19146.0	49.1
12	Жижиг төмөр эдлэл	мян.төг	116.0	964.5	328.5	1039.5	1814.0	1334.5	73.6
13	Дээл тэрлэг	шир	216	280	443	601	481	442	91.9
14	Цонх	м2	395.4	3906.2	4083.4	2707.2	2083.5	2870.9	137.8
15	Оёдол	мян.төг	1990.0	3031.1	8378.0	14133.1	17419.8	36227.4	208.0
16	Нүүрс	мян.тн	5.0	7.8	5.1	159.3	198.8	103.0	51.8
17	Блок	мян.шир	5.3	7.0	44.0	66.4	136.9	82.9	60.6
18	Тоосго	сая.ш						1.4	
19	Бетон зуурмаг	м3						3687	
20	Савласан цэвэр ус	мян.л	59.3	117.6	90.5	636.8	1723.7	2533.6	147.0
21	Сувагжуулалт	мян.м3	348.2	429.5	327.1	288.8	273.9	414.1	151.2
22	Ус түгээлт	мян.м3	456.5	619.1	577.7	475.4	488.2	673.3	137.9

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг харуулдаг гол үзүүлэлт бол ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин бөгөөд энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд аймагт өсөж ирсэн.

Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 11,8 хувиар буурсан байна. Салбараар авч үзвэл уул уурхайн олборлох салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 9,7 хувиар нэмэгдэж, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан хий, усан хангамжийн салбарын ажилчдын тоо 19,6-23,7 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн нийт ажиллагчдын дотор аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын эзлэх хувь 2013 онтой харьцуулахад 0,9 пунктээр буурсан байна.

7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО


Салбар	2009	2010	2011	2012	2013	2014	2014 2013
Бүгд	1533	1633	1695	1630	1974	1742	88.2
Олборлох үйлдвэр	579	554	800	730	677	743	109.7
Боловсруулах аж үйлдвэр	356	366	125	128	224	180	80.4
Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	598	713	770	772	1073	819	76.3

Аж үйлдвэрийн салбарын 2014 оны хөдөлмөрийн бүтээмж нь 2013 оноос 53,2 хувиар буурсан байна.

8. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, салбар, дэд салбараар, мян төг

Салбар	2011	2012	2013	2014
Уул уурхай олборлох аж үйлдвэр	5928.7	15286.1	17076.3	7986.8
Нүүрс олборлолт	5959.0	15799.4	17076.3	9679.1
Бусад ашигт малтмал олборлолт	5868.0	6259.3		5622.6
Боловсруулах аж үйлдвэр	2845.3	2698.0	3525.7	7178.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2363.4	2665.5	3940.5	6165.6
Хувцас үйлдвэрлэл	1002.7	1009.1	1755.0	2975.0
Гутал үйлдвэрлэл	784.8	220.3	557.1	2782.9
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	2004.8	1839.9	3890.0	6333.3
Машин тоног төхөөрөмжөөс бусад				
төмөр эдлэл үйлдвэрлэл	376.9	519.8	1342.9	346.0
Боловсруулах үйлдвэрийн бусад	5706.2	4563.7	5594.8	10266.3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	8671.1	9532.0	13415.3	13755.0
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	8666.6	9717.4	10766.0	13521.9
Ус ариутгал, усан хангамж	8685.8	8956.0	15896.0	14684.9
ДҮН	6502.7	11337.3	10947.4	10107.2

ЗУРАГ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО АЙМГИЙН НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ



2014 онд үйлдвэржүүлэлтийн чиглэлээр 12 иргэнд 682,5 сая төгрөгийн жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих зээл олгосон байна.

ГУРАВ. БАРИЛГЫН САЛБАР

2014 онд нийт 115802,4 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 27,4 хувиар буурсан байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 19.7 хувийг улсын төсвийн, 3,1 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Барилга угсралт их засварын ажлын 34,1 хувь нь орон сууцны барилга, 17,1 хувь нь орон сууцны бус барилга, 46,5 хувь нь инженерийн барилга, байгууламж, 2,2 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны барилгын эзлэх хувь 13,4 пункт, орон сууцны бус барилгынх 5,5 пункт, их засварын ажлынх 1,3 пунктээр нэмэгдэж, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 20,2 пунктээр буурсан байна.

9. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, оны үнээр, сая төгрөг

	2010	2011	2012	2013	2014
Улсын дү	442743.9	657196.0	919681.9	1719508.8	2146796.3
Төвийн бүс	24798.1	31168.9	37706.6	201893.4	385925.2
Дорноговь аймаг	1072.6	3873.5	4501.0	60509.1	115802.4
Улсын дүнд эзлэх хувь	0.2	0.6	0.5	3.5	5.4
Бүсийн дүнд эзлэх хувь	4.3	12.4	11.9	30.0	30.0

ЗУРАГ 4. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, мян төг



10. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая төгрөг, сумаар


	2010	2011	2012	2013	2014
ДҮН	25325.5	27077.9	28050.8	159534.9	115802.4
Айраг	18.6	94.0	1199.8	428.1	1911.6
Алтанширээ	16.0	209.5	134.3	26.0	383.2
Даланжаргалан		70.9	489.7	96.7	1599.4
Дэлгэрэх	61.6	8.5	109.8	274.0	663.0
Иххэт		53.3	90.5		53.9
Мандах	43.8	33.6	18.5	17.5	307.9
Өргөн	69.9	431.6	53.0	2.1	3848.3
Сайхандулаан	6.4	177.2	509.3	8.7	208.8
Улаанбадрах	20.5	629.7	39.6	75.0	262.0
Хатанбулаг	19.9	29.9	439.7	604.4	5687.4
Хөвсгөл	98.6	345.5	313.0	500.7	417.3
Эрдэнэ	21.7	24.4	82.6		1500.5
Сайншанд	20640.0	15457.2	16263.4	77840.8	42748.6
Замын-Үүд	4308.5	9512.6	8307.6	79660.9	56210.5

Тайлбар: 2010-2013 оны барилга угсралт их засварын ажлын дүнд гадаадын байгууллагын гүйцэтгэгчдийн барилга угсралт их засварын ажил орсон болно.

11. АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, м2, оны эцэст

	2010	2011	2012	2013	2014	2014 2013
Нийт талбай	12358.0	16720.8	25199.5	37030.5	30548.0	82.5
өмчийн Төрийн						
хэлбэр Хувийн	12358.0	16720.8	25199.5	37030.5	30548.0	82.5
Сууцны талбай	10053.5	14644.7	20343.7	30062.6	21648.5	72.0
өмчийн Төрийн						
хэлбэрээр: Хувийн	10053.5	14644.7	20343.7	30062.6	21648.5	72.0

ЗУРАГ 5. АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ өрх, хүн амын тоо



ДӨРӨВ. ЗАМ ТЭЭВЭР

Дорноговь аймгийн хэмжээнд 4436,8 км урт улс, орон нутгийн чанартай авто зам байгаагийн 10,9 хувь буюу 484,5 км нь хатуу хучилттай, 89,1 хувь буюу 3952,3 км нь сайжруулсан болон ердийн хөрсөн зам байна.

2014 онд Сайншанд суманд Эрх чөлөөний гудамжнаас Шизүокагийн гудамж хүртэлх 0,354 км авто зам ашиглалтанд оржээ.

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км ажиллагсадын тоо орлого зэрэг орно. Авто

тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгж, сумаас авч нэгтгэн Үндэсний Статистикийн хороонд дамжуулдаг

Ачаа эргэлт: Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч эргэлт: Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Шилжүүлсэн тонн.км: Тээврээр гүйцэтгэсэн олон түрүл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффициентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.

12. АВТО ТЭЭВРИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ОНЫ ЭЦЭСТ

	ХЭМЖИХ НЭГЖ	Онууд					2014 2013
		2010	2011	2012	2013	2014	
1. Ачаа эргэлт	м.тн.км	4653.2	26570.0	32240.0	42478.0	23153.0	54.5
2. Тээсэн ачаа	мян.тн	75.5	97.6	133.8	156.8	85.0	54.2
3. Зорчигч эргэлт	м.хүн.км	4017.3	1227.5	3653.2	3947.4	1470.1	37.2
4. Зорчигчид	мян.хүн	67.5	49.1	94.6	102.5	77.5	75.6
5. ТҮ-ийн орлого	сая.төг	692.5	1183.0	2467.0	10273.2	7991.3	77.8
6. Хамрагдсан нэгж	тоо	2	3	4	4	4	100.0

2014 онд 85.0 мянган тонн ачаа тээвэрлэж, 23153.0 мянган тонн км-ын ажил, 77.5 мянган зорчигч тээвэрлэж 1470.1 мянган хүн км-ын ажил гүйцэтгэсэн байна.

13. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ОНОШЛОГООНД ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛИЙН ТОО, СУМДААР ОНЫ ЭЦЭСТ

	2012	2013	2014	Үүнээс:			
				Автомашин	Мотоцикль	Чиргүүл	Бусад
Айраг	385	334	334	219	109	6	0
Алтанширээ	187	180	180	139	40	1	0
Даланжаргалан	348	231	231	194	36	0	1
Дэлгэрэх	280	243	243	196	47	0	0
Иххэт	302	146	146	125	19	1	1
Өргөн	152	227	227	184	39	3	1
Сайхандулаан	210	193	193	146	47	0	0
Мандах	156	148	148	114	31	2	1
Улаанбадрах	117	161	161	140	21	0	0
Хатанбулаг	333	351	351	291	59	0	1
Хөвсгөл	377	186	186	172	13	0	1
Эрдэнэ	142	181	181	116	64	0	1
Сайншанд	3449	4766	4729	3995	83	546	105
Замын-Үүд	4063	6025	5865	4617	0	1248	0
Бүгд	10501	13372	13175	10648	608	1807	112

2014 онд хийгдсэн тээврийн хэрэгслийн техникийн хяналт оношлогооны мэдээгээр 13175 авто машин, тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оноос 1.5 хувь буюу 197-оор буурчээ. Нийт тээврийн хэрэгслийн 46.3 хувийг суудлын, 17.1 хувийг ачааны автомашин, 3.3 хувийг автобус, 4.6 хувийг мотоцикл, 14.1 хувийг тусгай зориулалтын автомашин, 13.7 хувийг чиргүүл, 0.9 хувийг бусад механизмууд эзэлж байна. Харин 2014 оны жилийн эцсийн мал тооллогоор малчин өрхүүдэд тоологдсон мотоциклын тоог техникийн хяналт оношлогооны дүнтэй харьцуулж үзэхэд аймгийн хэмжээний 3 мотоцикл тутмын 1 нь хяналт оношлогоонд хамрагдсан дүн гарчээ.

ТАВ. ХОЛБОО

Шуудан холбооны үйлчилгээний орлого 489.2 сая төгрөг болж өмнөх оноос 24.2 хувиар өссөн байна. Суурин телефон цэгийн тоо 2014 онд 825 болж өмнөх оноос 6.2 хувиар буюу 48 хэрэглэгчээр нэмэгдсэн байна. Энэ онд нийт 11.7 мянган ширхэг албан бичиг, захидал, 584 ширхэг илгээмж (боодол) илгээсэн бол шуудангаар 556 зорчигч үйлчлүүлж 8.8 сая төгрөгийн орлого оруулжээ.

14. ХОЛБОО, ШУУДАН, оны эцэст

	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2014 2012
Үйлчилгээний орлого	сая.төг	238.4	301.2	346.5	393.8	489.2	124.2
Телефон яриа	мян.мин	1376.7	935.6	768.1	622.4	632.8	101.7
Телефон цэг	тоо	1094	934	868	777	825	106.2
Захидал	мян.шир	1.8	1.3	0.9	0.7	0.7	100.0
Боодол	ширхэг	937	355	222	246	395	160.6
Албан бичиг	мян.шир	10.0	11.4	9.0	10.0	11.7	117.0
Илгээлт	ширхэг	154	131	133	155	189	121.9
Буухиа	тоо	37	102	146	149	116	77.9
Зорчигчийн тоо	хүн	1686	2204	1599	580	556	95.9
Хамрагдсан нэгж	тоо	2	3	3	3	3	100.0

2014 онд Дорноговь аймагт үүрэн телефоны оператор 4 компанийн салбар ажиллаж байгааг байршлаар авч үзвэл юнителын 15, мобикомын 14, скайтелын 13, G-mobile 12, суурин телефон цэг 7 суурин газарт нийт 61 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлжээ. Үүрэн телефоны салбарууд энэ онд нийт 4226.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оныхоос 8.6 хувиар өсчээ. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор) 76.2 мянга орчим байгаа нь өмнөх оноос 6.3 мянгаар, 2010 оноос 41.9 мянган хэрэглэгчээр нэмэгджээ.

15. ТЕЛЕФОН УТАСНЫ СҮЛЖЭЭНИЙ БАЙРШИЛ 2014 оны 12-р сарын 31 -ний байдлаар

	МЦХК	Mobicom	Skytel	Unitel	G.mobile	дүн
1 Айраг						4
2 Алтанширээ						5
3 Даланжаргалан						4
4 Дэлгэрэх						4
5 Иххэт						2
6 Мандах						4
7 Өргөн						4
8 Сайхандулаан						4
9 Улаанбадрах						4
10 Хатанбулаг						3
11 Хөвсгөл						3
12 Эрдэнэ						4
13 Сайншанд						5
14 Зүүнбаян						5
15 Замын үүд						5
Дүн	7	14	13	15	12	61

16. ҮҮРЭН ТЕЛЕФОНЫ ҮЗҮҮЛЭЛТ, оны эцэст

	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2014 / 2013
Үүрэн телефон хэрэглэгчээс орсон орлого	сая.төг	2783.3	3393.2	3677.9	3892.0	4226.0	108.6
Үүрэн телефон хэрэглэгчидийн тоо	тоо	34330	45130	63100	69920	76220	109.0
Хамрагдсан нэгж	тоо	4	4	4	4	4	100.0

ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан болно.

Аж үйлдвэрийн борлуулалт нь улсын дүнд эзлэх хувь 2012-2014 жилүүдэд 0,3-0,1 хувь, бүсийн дүнд 1,8-1,1 хувь болж буурч байна.

Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь ангилж үзвэл цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 53,4 хувь, уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 34,4 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 7,8 хувь, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4,4 хувийг тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 11,8 хувиар буурсан байна. Салбараар авч үзвэл уул уурхайн олборлох салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 9,7 хувиар нэмэгдэж, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан хий, усан хангамжийн салбарын ажилчдын тоо 19,6-23,7 хувиар тус тус буурсан байна.

Барилга угсралт, их засварын ажил 2010 оноос хойш өссөн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд орон сууцны барилга угсралтын ажил нэмэгдсэнтэй холбоотой юм. Улсын дүнд эзлэх хувь 2012 онд 0,5 хувь, 2013 онд 3,5 хувь, 2014 онд 5,4 хувь, бүсийн дүнд эзлэх хувь 2012 онд 11,9 хувь, 2013, 2014 онд 30,0 хувь болж нэмэгдсэн байна.

Нийт барилга угсралтын ажилд орон сууцны барилгын гүйцэтгэл 2010 онд 7.1 хувь, 2011 онд 7.6 хувь, 2012 онд 7.9 хувь 2013 онд 44.8 хувь, 2014 онд 32,5 хувийг эзэлж байна.

Барилгын нийт хөрөнгө оруулалтын 19,7 хувийг улсын төсвийн, 3,1 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Барилга угсралт их засварын ажлын 34,1 хувь нь орон сууцны барилга, 17,1 хувь нь орон сууцны бус барилга, 46,5 хувь нь инженерийн барилга, байгууламж, 2,2 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны барилгын эзлэх хувь 13,4 пункт, орон сууцны бус барилгынх 5,5 пункт, их засварын ажлынх 1,3 пунктээр нэмэгдэж, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 20,2 пунктээр буурсан байна.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. www.1212.mn
2. www.dornogovi.nso.mn.
3. Дорноговь аймгийн Статистикийн эмхэтгэл 2014 онд

Хянасан: Статистикийн хэлтсийн дарга
Боловсруулсан: Ахлах мэргэжилтэн

Д.Мөнхтуяа
Б.Цэрэндорж